

САЛХИТЫН ИЛ УУРХАЙН ХӨРС ХУУЛАЛТ, ХҮДЭР ОЛБОРЛОЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 06-р сарын 04 өдөр

Ажлын нэр төрөл	Тайлбар
Ажил гүйцэтгэх үндэслэл	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн батлагдсан ТЭЗҮ, тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө зураг төсөл, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилгаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны стандарт, дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын ордын ил уурхайн хэсэгт хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажил гүйцэтгэнэ.
Захиалагч байгууллага	“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК
Төслийн байршил	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй ордын ил уурхай
Гэрээт ажлын зорилго, үр дүн	<p>Зорилго: “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Салхитын ордын ил уурхайн хүдэр хөрсийг мөргөцгөөс ангилан ухаж ачих, ялгах, тээвэрлэх, байршуулах, хүдрийн ул,тааз цэвэрлэх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, хүдрийн овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт хийх, уулын чулуулагт өрөмдлөг тэсэлгээ хийхэд бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд энэхүү ажлын зорилго оршино.</p> <p>Үр дүн: Ил уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажлыг батлагдсан ТЭЗҮ болон зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилгаа болон баяжуулах үйлдвэрийг хүдрээр хангах ажлыг таслахгүй явуулах ба ингэхдээ шимт хөрс хуулах, тээвэрлэх, байршуулах, овоолгын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлэх, тааз цэвэрлэх, хөмсөг хийх, ажлын болон ажлын бус хананы цэвэрлэгээ хийх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн усыг хуримтлуулах, зайлуулах, усан сан байгуулах, зумф ухах, ус шүүрүүлэлт хийх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, хөрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт хийх гэх мэт уурхайн олборлолт, уулын ажлын өрнөлттэй холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг байгаль орчны холбогдох хууль, стандартад нийцүүлж, гүйцэтгэнэ.</p>
Гүйцэтгэх ажил	<p>1. Хөрс хуулалт: Уурхайн хөрс ухаж ачих, шимт хөрс хуулах, тээвэрлэх, байршуулах, хөмсөг хийх, ажлын болон ажлын бус хананы цэвэрлэгээ хийх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн усыг хуримтлуулах, зайлуулах, усан сан байгуулах, зумф ухах, ус шүүрүүлэлт хийх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, хөрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт хийх гэх мэт уурхайн олборлолт, уулын ажлын өрнөлттэй холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг байгаль орчны холбогдох хууль, стандартад нийцүүлж, гүйцэтгэнэ.</p>

- 1.1 Тухайн сарын төлөвлөгөөг сар хааж акт үйлдсэн маркшейдерийн зураглал дээр үндэслэн сар бүрийн 01-ний өдрөөс 05-ны дотор захиалагч тал боловсруулж баталж өгнө.
- 1.2 Уурхайн болон овоолго, мөргөцгийн хажуугийн тогтворжилтод байнгын хяналт, судалгаа хийнэ. Нуралт, гулсалт үүссэн тохиолдолд тухайн хэсгийг аюулгүй болгох, нурсан материалыг шилжүүлэх арга хэмжээ авна. Мөргөцгийн нуралт гулсалтаас шалтгаалах асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. Хяналтын /мэргэжлийн/ тоног төхөөрөмжтэй байна.
- 1.3 Чулуулгийн тогтворжилтоос нь хамааруулан уурхайн ажлын болон ажлын бус догол, мөргөцгийн налууг 45-аас 55 градусаар гаргаж экскаватороор хананы цэвэрлэгээ хийнэ.
- 1.4 Уурхайн догол, мөргөцгийн улыг төлөвлөгдсөн загварчлалын өндөржилтийн түвшнээс дээш, доош 15 см-ийн хэлбэлзлээс илүү байлгаж болохгүй. Мөргөцгийн улыг түвшин хэмжигч /Laser level/ ашиглаж хянах. Уурхайд ухаж ачих ажлыг гүйцэтгэх экскаватор бүрийн ажлын талбайн улыг бульдозероор засаж тэгшилнэ.
- 1.5 Гүйцэтгэгч тал нь уурхайн ажлын бус доголыг хэлбэржүүлэх, замын хажуугийн хөмсөг тавих зэрэг ажлуудад зориулагдсан нөөц тоног төхөөрөмж / экскаватор, утгуурт ачигч гэх мэт/-тэй байна.
- 1.6 Аливаа инженерийн буюу бүтээлийн бус ажил нь нийт гүйцэтгэх уулын цулын 10%-иас хэтэрсэн, инженерийн ажилд хамаарахгүй хийгдэх нэмэлт ажлуудад ажлын гүйцэтгэлийн үнэлгээг уулын цулын 1 м3 үнэлгээний 70%-аар тооцно.
- 1.7 Захиалагч талаас баталж өгсөн сар бүрийн төлөвлөгөө дээр үндэслэн гүйцэтгэгч тал нь тухайн тайлант хугацааны календарчилсан төлөвлөгөө боловсруулан захиалагч талын инженер техникийн ажилтнаар батлуулан ажиллана.
- 1.8 Захиалагчийн шаардлагын дагуу сар бүрийн төлөвлөгөөний зургаас гадуур хийгдсэн ажил нь тухайн сард гүйцэтгэх уулын цулын 10 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг үнэ төлбөргүйгээр гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр тухайн жилийн хэмжээнд тооцон тухайн жилдээ хийж болно.
- 1.9 Улирал тутам хөндлөнгийн хяналтын хэмжилт оруулах
- 1.10 Хөрс тээврийн талын зай 2.0-3.5км

2. Хүдэр олборлолт:

Хүдрийг мөргөцгөөс ангилан ухаж ачих, ялгах, тээвэрлэх, байршуулах, хүдрийн ул,тааз цэвэрлэх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, хүдрийн овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт хийх гэх мэт уурхайн хүдэр олборлолттой холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

- 2.1 Уулын ажлын төлөвлөгөөг захиалагч талаас бүтэн жилээр нь нэгтгэж гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар хааж акт үйлдсэн маркшейдерийн зураглал дээр үндэслэн сар бүрийн 03-ээс 05 ны дотор захиалагч тал боловсруулж баталж өгнө.
- 2.2 Хүдрийн бүхий л мөргөцөгт тухайн хүдрийн биетийн тогтцод уялдсан тоног төхөөрөмжийг оновчтой сонгож ухалт, ачилт болон ангилан ялгалт хийж хаягдлыг 2.79%-аас бага, бохирдлыг хамгийн

	<p>бага буюу 3.94%-аас доош байлгах аар олборлолтын ажлыг зохион байгуулна. Хүдрийн блокийн тааз, ул цэвэрлэх ажлыг бульдозер, экскаватор хийж гүйцэтгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Хүдэр олборлох ажлыг хэрэгжүүлэхдээ захиалагчаас томилогдсон Инженер техникийн ажилтны хяналт дор зохион байгуулна. • Хяналтгүйгээр хүдэр олборлохыг бүрэн хориглоно. <p>2.3 Уурхайн мөргөцгөөс 400 мм-ээс ихгүй бүхэллэгтэй хүдэр олборлоно.</p> <p>2.4 Уурхайн хүдрийн мөргөцөг болон овоолгоос чанарын дээж авах ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг ажиллуулна.</p> <p>2.5 Ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ачилт хийж буй хэсгийн тээврийн зам, ажлын бүс, овоолго бүрд, ажлын талбайн гэрэлтүүлгийг хариуцна.</p> <p>2.6 Хүдрийн овоолгын болон агуулахын зам, овоолгын ул, талбай, хоорондын зам, хяналтын пүү, орж, гарах пүүний зам, худалдааны тээврийн машины зогсоолын зам, талбайг засах, өргөтгөх, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.7 Хүдрийг уурхайгаас олборлохдоо авто пүүгээр жинлүүлж төлөвлөгөөт хүдрийн овоолгод буулгана.</p> <p>2.8 Хүдэр тээврийг гүйцэтгэхдээ уурхайн авто пүүний хэмжээ, стандартад тохирсон тээврийн хэрэгсэл ашиглана.</p> <p>2.9 Хүдрийг олборлохдоо захиалагч компанид хүчин төгөлдөр хэрэгжиж буй дүрэм журмын дагуу хүдэр олборлох ажилбарыг гүйцэтгэнэ.</p> <p>2.9.1 Хүдэр олборлолтын ажлын даалгаварт:</p> <ul style="list-style-type: none"> • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокийн хүрээнд өртөгдсөн геологийн нөөцийн блокийн мэдээлэл / хүдрийн тонн, нөөцийн зэрэг, нөөцийн зэргээр блок тус бүрийн дугаар мөнгө, алтны агуулга нийт дундаж мөнгө, алтны агуулга, металл кг-аар/ • Хүдэр олборлолтын түвшний мэдээлэл тэсэлгээний блокийн дугаар • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокийн цооногоос авсан дээжийн тоо • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокоос авсан дээжийн уурхайн лабораторийн үр дүнгийн нэгтгэл. • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокоос авсан гадаад хяналтын дээжийн үр дүн уурхайн лабораторийн харьцуулалт /10 дээж тутамд 1 дээж авч харьцуулж хянаж байхаар/ • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокийн цооногийн үр дүнг харуулсан дэвсгэр зураг. • Хүдэр олборлолтын тэсэлгээний блокийн хүдэр хөрсний хил заагийг ялгасан дэвсгэр зураг. • Цооногийн үр дүнгээр гоц өндөр агуулга гарсан дохиололд гистограмм арга ашиглаж диаграммыг график байгуулж цооногийн үр дүнг шинэчлэх. • Агуулгаар ангилж олборлох хүдрийн хил зааг тодорхойлох хүрээ /агуулгаар ангилж 2 өөр овоолго үүсгэх дохиололд/
--	--

- Хүдэр олборлолтын тэсэлгээний блокоос экскаватороор мөнгөний өндөр болон бага агуулгаар холилт хийх чиглэлийн даалгавар.
- Хүдэр олборлолтын нийт доголын өндөр 6м, ашиглалтын үеийн хүдэр олборлолтын догол 2 дэд догол үүсгэж 3,3м ээр өдрийн цагаар хүдэр олборлох даалгавар боловсруулна.
- Ашиглалтын геологийн гаргасан ажлын даалгаврын дагуу агуулгаар ангилж олборлох хүдрийн хил заагийг маркшейдер инженер олборлох блокийн хүрээн дотор туузаар контор тавьж өгнө.
- Хүдэр олборлолтын өдөр болгоны ахилтыг ажлын даалгаврын дагуу блокийн хүрээ, улны түвшин, хүдэр олборлолтын орлын ахилт, олборлолтын доголын дэд догол түвшин дээрх өдөр тутмын ахилтыг захиалагч компанийн ашиглалтын геологич, маркшейдер хэмжилт хийх.

2.10 Хүдэр олборлолтын талын зай 2.0-3.8 км

3. Зам талбай засах, услах:

Уурхайн лицензийн хил доторхи хөрс, хүдэр тээврийн зам, талбайг засах, өргөтгөх, шинээр барих, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

3.1 Уурхайн дотоод тээврийн налуу (траншейн зам) зам болон хөрсний овоолгын налуу зам, технологийн авто тээврийн замуудад хур тунадас орсон үед халтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлж хайргажуулах, хүйтний улиралд усалгаа хийж болохгүй үед тоос дарах химийн бодис ашиглаж улирлын болон цаг агаарын саатлаас шалтгаалж гардаг сул зогсолтыг багасгах нөхцөл бололцоог бий болгож ажиллана.

3.2 Захиалагчаас гаргасан төлөвлөгөө, зураг төслийн хүрээнд зам талбайд өргөтгөл хийх, шинээр барих, ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

4. Уурхайн ус таталт, шүүрүүлэлт:

4.1 Уурхайн ухаш, бусад байгууламжуудыг гадаргын болон гэнэтийн үерийн уснаас хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, үерийн усны урсах голдирол, чиглэлийг өөрчлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

4.2 Уурхайн мөргөцөгт шүүрч орох усыг уурхайн хамгийн доод түвшнээс доош байлгаж шүүрүүлэлт, ус таталт хийнэ.

4.3 Уурхайн талбайн гадна төлөвлөгдсөн талбайд мөргөцөгөөс шүүрүүлж, насосоор татсан усыг хуримтлуулах стандарт шаардлагад нийцсэн усан сан байгуулна.

4.4 Уурхайн дотоод шүүрлийн болон гадаргуугийн хур тунадас, үерийн усыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүйгээс үүсэх хариуцлагыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

5. Хөрс болон хүдрийн овоолго үүсгэх:

5.1 Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу үндсэн хөрс, элс хайрганы холимог хөрс (шимэрхэг), шимт хөрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

5.2 Хөрсний овоолго үүсгэхдээ захиалагч талын төлөвлөлтийн дагуу догол, түүний налууг гаргаж хэлбэршүүлнэ.

- 5.3 Хөрсний овоолгод түрэлт хийх бульдозертой байна.
- 5.4 Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу хүдрийн овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, ачилтын тавцан шинээр үүсгэх ажлуудыг гүйцэтгэнэ.
- 5.5 Захиалагчийн шийдвэрээр олборлосон хүдрийг чанараар нь ангилан овоолго үүсгэх ба овоолгуудад чанарын холилт хийнэ.
- 5.6 Хүдрийн овоолгод бохирдолттой хүдэр буулгасан тохиолдолд шаардлагатай цэвэрлэгээ тогтмол хийнэ.
- 5.7 Ил уурхайгаас олборлох хүдрийг баяжуулах үйлдвэрийн талбайд холилт хийж овоолго үүсгэх
- Баяжуулах үйлдвэрийн хүдрийн талбайд төлөвлөлтийн инженер ил уурхайгаас олборлох хүдрийн овоолгын талбайн хэмжээ, овоолгын өндөр, овоолгын налууугийн градус, овоолго хоорондын аюулгүйн зай, техник хоорондын ажиллах зай, рамп, дизайны төлөвлөгөө боловсруулж СУБҮ-ийн ээлжийн ахлахад танилцуулж СУБҮ-ийн захирлаар баталгаажуулна.
 - Овоолгын өндөр нь төлөвлөсөн талбайн улны түвшнээс дээш 6м-ээс ихгүй байхаар овоолго төлөвлөх
 - Хүдрийн овоолгын батлагдсан төлөвлөгөөний дагуу маркшейдер инженер овоолгын хүрээ хил хязгаарыг тавьж өгч хүдрийн овоолгын өндөр, овоолгын хажуугийн налуу, рамп, овоолго хоорондын зай, овоолгын дизайн, овоолгын холилтын технологи дээр хяналт тавьж ажиллана.
 - Баяжуулах үйлдвэрийн хүдрийн талбайд ил уурхайгаас олборлосон мөнгөний өндөр болон ядуу агуулгаар 60 см ээр сандвичлэн давхраас байдлаар бульдозероор түрж холилт хийж овоолго үүсгэнэ.
 - Овоолго агуулгаар хольж үүсгэх технологийн холилт дээр ашиглалтын геологич, маркшейдер инженер нар 60 см-ийн давхраас бүр дээр хэмжилт хийж хяналт тавьж ажиллана
 - Овоолгын 60см-ээр сандвичлэн хураах давхаргын үелэл нь хамгийн ихдээ 10 үе байна.

6. Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлт:

- 6.1 Гүйцэтгэгч нь байгаль орчин хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт олборлогчийн хүлээх үүргийг хуваарийн дагуу биелүүлж, биелэлтийг захиалагчид улирал бүр тайлагнана.
- 6.2 Хаалтын менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн журам, өнгөн хөрстэй ажиллах журам, шимт хөрс хуулах журам болон MNS 5916:2008 стандартын дагуу хуулах, овоолго үүсгэх, зүлэгжүүлэх, хамгаалалт хийх ажлуудыг гүйцэтгэнэ.
- 6.3 Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг хог хаягдлын тухай хууль, журам, стандарт болон байгаль орчны журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, аюултай хог хаягдлыг устгах буюу саармагжуулах, хог хаягдлын стандарт бүхий байгууламжийг барих, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж гэрээт хугацаанд буюу тухайн жилдээ төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.

- 6.4 Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцөлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна.
- 6.5 Хаалтын жишиг төлөвлөгөөний дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж, тайлангийн хэрэгжилтийг ханган ажиллах
- 6.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хаалтын жишиг төлөвлөгөөний дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн тохиолдолд захиалагч талтай хамтран орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байна.
- 6.7 Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн эдэлбэр газарт мод тарих ажлыг зохион байгуулж ажилласан байна.
- 6.8 Байгаль орчинтой холбоотой олон нийтийн ажилд идэвхтэй оролцох

7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:

- 7.1 Уулын ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, ХАБЭА-н тухай хууль, ХАБЭА-н дүрэм журам, аюулгүй ажиллагааны заавруудыг чанд баримтлан нийт ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.
- 7.2 Ажил гүйцэтгэгч тал ХАБЭАБО-н хэлтэстэй байх бөгөөд ХАБЭА-н мэргэжилтэн, уурхайн эмч, эрүүл ахуйч эмч, гал гамшгийн мэргэжилтэн бие бүрэлдэхүүнийг ажиллуулна.
- 7.3 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтэс /цаашид ХАБЭАБО-н хэлтэс/-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байх бөгөөд сар, улирал, жилийн төлөвлөгөөг болон тайланг захиалагч талын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэст /цаашид ХАБЭАБОХ/ мэдээллийг хүргүүлэн ажиллана.
- 7.4 Мэргэжлээс шалтгаалах өвчний / цаашид МШӨ гэх/ талаар нийт ажилтнуудад судалгааг хийж захиалагч талд мэдээллийг хүргүүлэн ажиллана.
- 7.5 ХАБЭА-н тухай хуулийн дагуу ХАБЭА-н сургалтын хөтөлбөрийг боловсруулан захиалагч талд мэдээллийг өгөх ба нийт ажилтны сургалт зохион байгуулсан талаарх мэдээллийг хүргүүлэн ажиллана.
- 7.6 Захиалагч талаас нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан талаар мэдээллийг хүргүүлэн ажиллах ба уурхайн эмчид мэдээллийг өгч өдөр тутмын эрүүл мэндийн талаарх ажлын тайланг хүргүүлэн ажиллана.
- 7.7 Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Мөн үйл ажиллагаандаа MNS ISO 45001 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм, журам, аюулгүй ажиллагааны заавруудыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана.

- 7.8 Ажил гүйцэтгэгч талын Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс нь осол, осол дөхсөн тохиолдлуудын талаар үнэн бодитоор мэдээлж ажиллах ба үйлдвэрлэлийн осол, осол дөхсөн тохиолдлуудын судалгааг хийж захиалагч талд мэдээллийг нуун дарагдуулалгүй хүргүүлэн ажиллана.
- 7.9 Ажил гүйцэтгэгч тал өдөр тутам ажлын байранд аюулыг мэдээлэх хуудсыг ажилтнуудаар бөглүүлэн аливаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ХАБЭАБО-н хэлтэст мэдээллийг хүргүүлэн ажиллана.
- 7.10 Ажил гүйцэтгэгч тал нийт ажилтнуудад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг ХАБЭА-н тухай хуулийн дагуу ажилтнууддаа олгож ажиллана.
- 7.11 Ажил гүйцэтгэгч тал ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хийж захиалагч талын ХАБЭАБО-н хэлтэстэй хамтран ажиллана.
- 7.12 Ажил гүйцэтгэгч тал ажлын байран дах аюултай нөхцөл байдлыг захиалагч талын ХАБЭАБО-н хэлтэст болон Салхит уулын баяжуулах үйлдвэрийн удирдлагуудад мэдээллийг шуурхай мэдээлж ажиллана.
- 7.13 Ажил гүйцэтгэгч тал захиалагч талын дотоод журмын дагуу ил уурхайн олборлолтын бүсэд замын хөдөлгөөнд оролцох автомашин, өөрөө явагч машин механизмуудыг бүрэн бүтэн байдлыг хангуулан, богино долгионы станц, туг, маяк, LV, SV, туслах техникүүд болон хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин механизмуудад парк дугаарууд, суурин станцыг суурилуулан байршуулсан байна.
- 7.14 Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ.
- 7.15 Захиалагч талаас шаардах Ил уурхайн олборлолтын бүсэд гэрэл гэрэлтүүлэг, замын болон бусад тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажиллах шаардлагатай.
- 7.16 Ажил гүйцэтгэгч тал галын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба гал, гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж ажиллана. Мэдээллийг захиалагч талд хүргүүлэн ажиллана.
- 7.17 Ажил гүйцэтгэгч тал нийт автомашин, өөрөө явагч машин механизмуудын галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх шаардлагатай.
- 7.18 Ил уурхайн олборлолтын бүсэд болон засварын хэсэг, ажилчдын кемп, ажлын байруудад галын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулах, захиалагч талаас гал, гамшгийн сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд хамран ажиллана.
- 7.19 Захиалагч талаас ХАБЭА-н I, II, III, IV-р шатны хяналт зохион байгуулах ажлын хүрээнд үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулан ажиллах шаардлагатай.
- 7.20 Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны /цаашид ХАБЭАБО гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

	<p>7.21 ХАБЭАБО-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй.</p> <p>8. Цахилгаан хангамж:</p> <p>8.1 Захиалагч талаас хүлээлгэж өгсөн цахилгаан байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүд, 400кВа хүчин чадалтай КТПН-3 дэд станцын 0.4кВ талын цахилгаан тоноглолуудад үзлэг, засвар үйлчилгээг хийж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах.</p> <p>8.2 Ажилчдын болон өөрсдийн байрлах кемп, оффис, засварын цех болон бусад объектуудынхаа цахилгаан хангамж шугам сүлжээний ашиглалтыг хариуцан үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах.</p> <p>8.3 Сар бүр хэрэглэсэн эрчим хүчний хэрэглээгээ тоолуураар тооцон гаргасан акттай танилцаж тооцоо хийх.</p> <p>8.4 Ээлжийн цахилгааны инженер, цахилгаанчин нар нь аюулгүй ажиллагааны мэргэшлийн зохих групптэй ажилтан байх ба “Цахилгаан байгууламжийн ашиглалын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм” бусад холбогдох журам заавар, норм, стандартын шаардлагыг дагаж мөрдөнө.</p> <p>8.5 0.4кВ-ын цахилгаан байгууламж, цахилгаан хангамжийн төлөвлөгөөт үзлэг, засвар үйлчилгээний хуваарийг сар бүрийн эхэнд гаргаж захиалагч байгууллагын цахилгааны инженерээр хянуулж ажиллах.</p> <p>8.6 Ашиглалтын үеийн засвар үйлчилгээний багаж, тоног төхөөрөмж, сэлбэг материалууд, нөөц материалуудаа төсөл хэрэгжүүлэгч хариуцаж ажиллах.</p>
--	---

	№	Албан тушаал	Тоо	Мэргэжил	Туршлага, ажилласан жил
Ажиллах хүч	1	Ашиглалтын инженер	2	Уул уурхай, ашиглалтын инженер мэргэжилтэй байна.	Уул уурхайн салбарт 3 ба түүнээс дээш жил ажилласан байх
	2	Төслийн менежер	1	Уул уурхай, ашиглалтын инженер мэргэжилтэй байна.	5 ба түүнээс дээш жил төсөл удирдсан туршлагатай байх
	3	Маркшейдер	2	Уул уурхайн маркшейдер мэргэжилтэй байх	Уул уурхайн салбарт 3 ба түүнээс дээш жил ажилласан байх
	4	Ашиглалтын геологич	2	Геологич мэргэжилтэй байх	Уул уурхайн салбарт 3 ба түүнээс дээш жил ажилласан байх
	5	Уулын мастер	4	Уул уурхай, ашиглалтын инженер мэргэжилтэй байна.	1 ба түүнээс дээш жил ажилласан байх
	6	Диспетчер	2	Техникийн үйлчилгээ, Инженер эсвэл үүнтэй ижил төстэй мэргэшлийн чиглэлийн бакалавр	1 ба түүнээс дээш жил
	7	Оператор–тээврийн төхөөрөмж /дамп, хово/	72	<ul style="list-style-type: none"> • “М” ангиллын жолооны үнэмлэхтэй байх • Оператор, хүнд машин механизмын үнэмлэх сертификаттай байх 	5 ба түүнээс дээш жил
	8	Оператор – экскаватор	12	<ul style="list-style-type: none"> • “М” ангиллын жолооны үнэмлэхтэй байх • Оператор, хүнд машин механизмын үнэмлэх сертификаттай байх 	5 ба түүнээс дээш жил
	9	Оператор – бульдозер, грейдер, утгуурт ачигч, усны машин	20	<ul style="list-style-type: none"> • “М” ангиллын жолооны үнэмлэхтэй байх • Оператор, хүнд машин механизмын үнэмлэх сертификаттай байх 	5 ба түүнээс дээш жил
	10	Эмч	2	Эмчлэх эрхтэй байх	Мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх
	11	ХАБЭА-н мэргэжилтэн	2	ХАБЭА сургаалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх	ХАБЭА-н ажилтнаар 3 болон түүнээс дээш ажилласан байх
	12	Байгаль орчин, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн	1	Байгаль орчны мэргэжилтэн мэргэжилтэй байх	Мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх
	13	Цахилгааны инженер	2	Уул уурхайн цахилгааны инженер мэргэжилтэй байх	
	14	Цахилгаанчин	2	Цахилгааны инженер мэргэжилтэй байх	
	15	Механик инженер	2	Уул уурхайн механик мэргэжилтэй байх	Мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан байх
	16	Автын цахилгааны инженер	2	Уул уурхайн механик мэргэжилтэй байх	
	17	Засварын бригад	1	Уул уурхайн механик мэргэжилтэй байх	

Уурхайд ажиллах шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо, Шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт:

Машин механизм, тоног төхөөрөмж				
№	Машин механизмын нэр	Тоо	Хүчин чадал	Өөрийн эзэмшлийн эсэх
1	Автосамосвал	18	60 тонн даацтай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
2	Экскаватор	3	3.3-6.5 м3 хэмжээтэй шанагатай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
3	Авто ачигч	2	3.2-5.5м3 багтаамжтай шанагатай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
4	Бульдозер	2	3.2-5.5м3 багтаамжтай шанагатай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
5	Автогрейдер	1	-	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
6	Усны машин	1	20-40 тн багтаамжтай зориулалтын усалгааны зам	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
7	Түлшний машин	1	5 тонноос дээш багтаамжтай түлш түгээх, зам талбай услах зориулалтын авто машин	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
8	Уурхайн бүсэд хүн тээвэр хийх зориулалтын авто машин	1	Жолооны хүрд нь зөв талдаа байх ба цагаан өнгийн байх шаардлагатай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
10	Ус татах насос,помп	2	70-100м-ын ус татах хүчин чадалтай	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
11	Цэвэр ус зөөх машин	1	5тн багтаамжтай цэвэр ус зөөх түгээх зориулалтын авто машин	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
12	Пүү	1	Өөрийн тээврийн машин механизмд таарсан пүүтэй байх	Өөрийн эзэмшлийн/Түрээсийн
Багаж хэрэгсэл				
№	Багажийн нэр	Тоо	Тайлбар	
1	Маркшейдерийн хэмжилт хийх цогц багаж	1	Өөрийн эзэмшлийн болон түрээсийн	

Техникийн шаардлага	
Төлбөр тооцоо	<ul style="list-style-type: none"> Уулын ажлыг гүйцэтгэгч компани нь Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг сар бүр 90%-иас дээш гүйцэтгэх ёстой бөгөөд уулын ажлын төлөвлөгөөний биелэлтэд хүрээгүй, дараа сард нөхөж гүйцэтгэх тохиолдолд уулын цулын нэгж үнэлгээг бууруулж тооцно. Үнэлгээг тооцоходоо захиалагчийн баталсан үнэлгээ тооцох хуудсаар үнэлнэ./ Олборлож эхлэхээс өмнөх болон тэслэгдсэн блокийн ухаж ачсаны дараах маркшейдерийн хэмжилтийг харьцуулж уулын цулыг тооцно.

	<ul style="list-style-type: none"> • Гэрээнд заасан нийт ажлын талбайд хийгдэх ажил нь төлөвлөгөөний дагуу явагдах ба төлөвлөгөөт хэмжээ нь өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан актыг үндэслэн төлбөрийг тооцно. • Уулын ажлыг сар бүрийн 01-ний өдрөөр 2 талын маркшейдерийн хэмжилтээр дүгнэх ба уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажлын талбай ул, овор ихтэй чулуулгийн хэмжээ заасан шаардлагын дагуу хүлээн авч, тооцоо хийгдэнэ. • Захиалагч тал нь гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг сар бүр актаар хүлээн авна. 																								
Ажлыг гүйцэтгэх хугацаа	<p>Олборлох уулын цулын хэмжээ:</p> <table border="1" data-bbox="507 589 1465 656"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Сар бүр</td> <td>м3</td> <td>208 400</td> </tr> </tbody> </table> <p>Салхитын ил уурхайн уулын ажлын 2024 оны төлөвлөгөө/сард/:</p> <table border="1" data-bbox="507 712 1465 880"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлтүүд</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Сар бүрийн төлөвлөгөө</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт уулын цул</td> <td>мян.м3</td> <td>208 400</td> </tr> <tr> <td rowspan="2">2</td> <td rowspan="2">Хүдэр олборлолт</td> <td>мян.тн</td> <td>50 000</td> </tr> <tr> <td>мян.м3</td> <td>18 726</td> </tr> <tr> <td>3</td> <td>Эзлэхүүн жин</td> <td>т/м3</td> <td>2.67</td> </tr> </tbody> </table> <p>Гэрээт ажлын нийт хэмжээг гэрээний тусгай нөхцөлөөр зааж өгнө.</p>	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Сар бүр	м3	208 400	№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Сар бүрийн төлөвлөгөө	1	Нийт уулын цул	мян.м3	208 400	2	Хүдэр олборлолт	мян.тн	50 000	мян.м3	18 726	3	Эзлэхүүн жин	т/м3	2.67
Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ																							
Сар бүр	м3	208 400																							
№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Сар бүрийн төлөвлөгөө																						
1	Нийт уулын цул	мян.м3	208 400																						
2	Хүдэр олборлолт	мян.тн	50 000																						
		мян.м3	18 726																						
3	Эзлэхүүн жин	т/м3	2.67																						
Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Компани өөрийн ажилтнуудыг байрлуулах түр кемптэй байх • Компани техник, тоног төхөөрөмжүүдийг засварлах гражтай байх • Катерингийн үйлчилгээг зөвшөөрөгдсөн компаниас авах 																								